

## МОНГОЛ БИЙ БИЕЛЭГИЙН ДОХИО ЗАНГЫН ЗАРИМ ТАЙЛАЛ

Ч. Болдбаатар, Т. Цэцэгжаргал \*

Бүжиг биеэ даасан төрөл зүйл болж хөгжихөөс өмнөх шатанд хамаарах шүтлэг-зан үйлийн хам шинжит өргөл залбирлын соёл дотор бидний судалж буй язгуур [БИЙ БИЕЛЭГ]-ийг багтаан үзэж болох билээ. Үүнийг орчин цагийн урлагийн морфолог үндэслэлээр угсаатны буюу [ЭТНО БҮЖИГ] хэмээн нэрийддэг. Энэ нь ч зүйн хэрэг.

Бий биелэгийн морфогенезис гарвал нь тайлга тахилгын үйл холбогдлоос эхтэй учир яг бүжгийн хэлний тогтолцоогоор буюу утгад хөдөлгөөн хувилбарших галбир зохирлоор шууд тайлбарлах боломжгүй юм. Үүний оронд хүмүүний оршихуйд ихээхэн хамааралтай инстинктив хамгаалал, хүсэмжлэн дуурайх мистик шалтгаанд суурилан ойлговол зохилтой хэмээн таамаглаж байна. Яагаад гэвэл, хориг цээрт нуугдмал шинжтэй байдаг бибинар утгалбарт далд хүчийг (эзэн савдаг, сэтэрт амьтан) урьд урьдаас хэтийдэн оноох арга (мистификаци) илүүтэй ойр тусдаг. Тэгээд ч муу, сайн ёр бэлгээр сэрэгдэх адилсал, зэрэгцэл бүхий ассоциацийн зарчмаар үүдэх мистик төсөөг илтгэх нэгэн зүйлд бидний нягтлаж буй монгол бий биелэгийн дохио зангын зангилаа асуудал яригдахад хүрсэн билээ. Тухайлбал, ан авын ёслолд үйлддэг чатга байна. Чатга тавина гэдэгт зөвхөн биелэх агсал шившлэг орохгүй. Түүнд бас амьтны амь сүнсний аврахын цагт гэтэлгэх зурлага (дом) хамтдаа үйлших явдал бий. Энэ нь мистик сэтгэмжийн хувиар бол юм ба үйлдэл хоёрыг зэрэг цагжуулан ойлгох жир бус шинжтэй үзэхүйгээс үүдэлтэй байх аж. Үүнээс үзвэл, эрт баларын онч дохио гэдэг нь амь зуулгад хэрэгцээтэй бодит үйл ажиллагаатай зүйл байдгаараа онцлог. Тиймээс л эрт цагт хүмүүс зэрлэг араатнаас төдийгүй муу ёрын зүсэн зүйлийн сүнснээс айдас сүүдрээ аврах, ад зэтгэрээс ангижрах гэж дуу чимээгээр шившиж, занга гороо тавих болдог байж л дээ. Ингэх нь аргагүй юм. Эдгээр баримтыг зориуд дурдсаны шалтгаан нь үгээр хэлж эс болох зөвхөн биеэр хөдөлж гороолох бараг л пантомимо шиг сакраль дохио занга энд яригдах болсноос тэр. Уг нь, утгачилах аргагүй аморф давхцалыг илэрхийлэх хамтын үл ухамсарлахуйн үүдэл, синкретик тогтолд бий биелэгийг хам ухаарч болох мэт санагдана. Бий биелэгийг чухамдаа тэс өөр хоёр зүйлийг төслөг шинжээр өөр хооронд нь зэрэгцүүлэн байршуулж, нэгийг нөгөөгийн орлуулга болгож сэтэрлэх биеэлбэр үзэгдэл гэж ойлгож болох талтай. Үүнд Клод Леви-Стросын ярьдаг менталь бүтэц, Мишель Фукогийн тавьсан дискурсив боломж гэх ойлголт, Зигмунд Фройддын табугаас аваад бусад олон судлаачдын хөндсөн, ялангуяа амбивалент шинжийн тухай

---

\* МУИС-ийн МХСС-ийн Урлаг судлалын тэнхим

тайлбар нь бидний судалж буй асуудлыг нягталж мөшгөхөд онолын баттай үндэслэгээ болж өгөв. Иймийн учир монгол бий биелэгийн уламжлалыг эртний онго шүтлэг, түүний зан үйлд хэрэглэдэг дохио зангын ул мөрөөр судлахыг оролдсоноо энд өгүүлсэн болно.

Нэг ёсондоо биеэлбэрийн тэмдэглэг шинж нь түүнд харгалзах амбивалент дүр буюу домогзүйн ухагдахууныг орлуулан солих зайлшгүй байрлалд баригдмал бөгөөд “хэлмэр” гэж томъёолмоор зөн совингоор дүүрэн билээ. Жишээ нь, ураг төрлийн (цусан) холбоог энгийн зурлага, биеэлбэрээр оноох явдал элбэг байдаг. Үүний баримтыг хадан зурлагын тэмдэглэгээнээс ажиглаж болох байна. Ан авын ёсыг, тэр тусмаа хориг цээрийг эрхэмлэж байсан эртний дүрслэмжид тусгалаа ологч айдасын эрхшээлд хүлэгдмэл тэмдэг дохиог нэрлүүштэй. Хаданд тэрлэсэн амьтны хий сүг дор толбо тавьж хонхойлсон нь үүнийг магадлана. Ийм занга нь ав хомроого урьдаас гороолох буюу “шарх” оноосны дом<sup>1</sup> төдийгүй уул усны эзэн савдгийг аргадан, эрхшээлд нь буйг илтгэх “нүд” болой. Үүгээр тогтохгүй хээлийн тэмдэг буюу “умай” гэж давхар ойлгож болох зүйл. “Нүд” тавьж харуулах нь сахиулсан амьтан гэсэн үг (чатга) байж, ерөөс босоо чигтэй тэрлүүлдэг нь сүнсийг аргадсан хориг болдог<sup>2</sup>. Иймэрхүү бэлгэ, бэлгэдлийн нууц хэтийдэл (мистик) зурлага өөрөө адилсах ба зэрэгцэх бибинар өгөгдөл түлхүүрээр тайлагддагийг дахин санахад илүүдэхгүй болов уу. Эртний хүмүүс инстинктив хамгааллаа гээвэл амьдрах боломжоо алддаг гэж ойлгодог нь үүнээс эхтэй билээ.

Энэчлэн амбивалент харилцаагаар орших давхацмал утгалбарын тайлал нь бий биелэгийн дохио зангын тайлбарлалд бас нэгэн адил хамаатай байх шиг байна. Үүнийг монгол бий биелэгийн хэлмэртээ хэлбэршин шалтгаалцсан шинжийг үйл шилжих утгалбар болон дан хөдөлгөөн, онч дохионоос дам үүссэн гэх түлхүүр бүтцээс ажиглаж болно. Мистик шалтгаалцал байхгүйгээр үйл үйлдэл бүтэх ч үгүй, хэлмэрийн далд дохио шилжих ч үгүй юм. Давхацмал байрших юм ба үйлдлийн хам утгалбар нь түүнтэй зэрэгцэн орших нөгөө юмыг заахын дээр бас үйлдэлшүүлдэг. Энэ мэтээр бибинар тэмдэг зөвхөн далд юмыг заах биш, бодит үйлтэйгээ шалтгаалцан орших аж. Үүнийг түүхч Э.Гомбрих анзаарч, picture and statues, in other words are used to work magic<sup>3</sup> хэмээснээс гэхчилэн бичсэн хэрэг. Баримт юуг хэлээд байна гэвэл, биеэр гүйцэлдүүлдэг чатга занга ч ялгаагүй амбивалент шинж бүхий аморф хэллэгээс үүссэн гэх үндсийг төсөөлөх боломжийг нээж буй билээ. Тэгвэл үр удам залгаж, хишиг даллага болгосон ер бусын өргөлд мөргөл цацал ямар учир холбогдолтойг товчхон дурдаж болох юм.

Гэвч, энд заавал хэлэлцэгдэх ёстой ойлголт бас байна. Хориг цээрийн содон үзэгдлийн дотор айдасын сэрэл мэдрэмжүүдтэй холбогдсон тайлбар нь сонирхол татдаг. Ялангуяа З.Фройдын давтан хэлдэг хориг цээрийн болгоомжлол чухлаар яригдана. Үхлээр шийтгэгдэхээс болгоомжилдог нь хүн өөрөө шийтгэл хүлээхээс айсан хэрэг огт биш, хамгийн гол нь бусдыг давхар дагуулж, бүлдээ гай зовлон авчирахаас гадна хойт төрөлдөө үйлийн үр тээх аюултайг мэдэрснээс тэр. Тийм болохоор амь бүрэлгэхийг ихэд цээрлэдэг. Болгоомж алдваас гэм зэм эргээд бүл омгоор тогтохгүй элэнц хуланцад

<sup>1</sup>) Болдбаатар Ч. Амьтны сэдэвт сүг зурлагыг тайлбарлах зарим асуудал-Монгол судлал БХХХ, (328), УБ., 2010, тал 139.

<sup>2</sup>) Мөн өгүүлэлд, тал 141.

<sup>3</sup>) Gombrich E.H. The story of Art-Strange Beginnings, W., 1996, p.18.

нүүрлэх барцадтай хэмээнэ. Эндээс айдасын язгуур чанараас нэлээдгүй нь гэмших сэтгэлд холбогддогийг ойлгож болно. Амьтныг хөнөөх явдал бол бүл омгийн цус асгарахаас ялгаагүй зүйл гэж төсөөлөгддөг. Түүнчлэн хориг цээр гэж юу болох тухайд Смит Робинсоны судалгаа чамгүй хариулт өгсөн бөгөөд омог ба сахиулсан амьтан хоорондын эрхэм дээд холбоо хориг цээрээр дархлагддагийг, цусны нууц учир холбогдол тотемист сэтгэлгээнд, ялангуяа амбивалент шинжээр илэрдгийг тодорхой баримтаар дурдаж магадлажээ. Магадтай нь, энэ хорвоод тохиосон зүйл бүхэн тэндээ дуусвар болдоггүйг сануулсан дохио гэхүү дээ. Уршиг нь уул усны эздийг догшируулаад зогсохгүй улмаар ан авын хишиг барагдах гай авчирч байгаа явдал болой. Энэ бүхнийг бий биелэгийн дохио зангыг задалж шинжлэхтэй холбон ойлгох хэрэгтэй.

Учир нь, угсаатны бий биелэгт холбогдох хамтын үл ухамсарлахуй бүхий зөн түлхэцийг дан хувь хүнд биш харин заавал омог бүлийн хүрээнд авч үзэх ёстой байдаг. Яагаад гэвэл, хориг цээрт зөрчлийг үл харгалзах байдал гол юм. Тухайлбал, олшруулахын зэрэгт үйлдэх хам шинж давтагдмал бөгөөд хориг цээрийн нэгж хэсгүүд бүхэл зүйлтэйгээ (далд юмтай) адил байх хувьтай гэсэн үг. Энэ нь этнобиелэгийн *pars pro toto* зарчмыг тодотгож буй хэрэг. *Pars pro toto* хэмээх нь бүхэл ба хэсэг адилсах зарчмын томъёолол. Эндээс Э.Кассирерийн ярьдаг домгийн орон цаг, үйлдэлт төсөөлөл урган гарч тайлбарлагдана. Синкретик сэтгэмжээр бол онго хийгээд шидийг тайх ёсонд тэрлэгддэг “амьдрал ба үхэл” гэдэг нь эсрэгцсэн утгатай биш харин зэрэгцэн оршиж, улмаар “ургамал ба амьтан” гэсэн ондоошлоор биш адилсалын ассоциацаар солигддог аж. Түүнчлэн тэдгээрийг идэш болгон хэрэглэх далд дохио хамтдаа тээгддэг нь дом шившлэг бүхий пантомимыг бибинар шинжтэй гэж үзэхээс өөр аргагүйд хүргэсэн билээ. Тухайн “бинар” зангилаанд хүмүүний удмын хэлхээс үл тасалдах тухай төсөөлөл нэвт шингэдэгээс гадна үхэл-төрөлтийн мөчлөг шиг залгавар үйлийг даван гэтэлгэх явдал хамтаар оршдог. Энд “юм” ба түүний “нөхцөл” огт яригдалгүй дан омог ба далд юм хоорондын харилцаан дахь саад тотгор хийгээд зөн совин л бий. Иймээс л К.Леви-Стросс домгийн бүтцийг түүнээс өмнө судалсан Э.Тайлор, Ж.Фрейзер, Э.Дюркгеймийн хандлагыг шүүмжилсэн нь бас чиг ор үндэсгүй зүйл биш байлаа. Эрт баларын аливаа синкретик тэмдэгт болоод тайлга тахилгын үйлдлүүд итгэл үнэмшлийн наминчлалгүй байснаараа онцлог гэдгийг ойлгох хэрэгтэй. Сүг босгох зурлага ч тэр, бий биеэлбэр ч тэр уран сайхны сэтгэмжээс илт ангид байхын сацуу зан үйлдэл болж, түүний дотор хэрэгждэг гэж ойлгох нь нэн чухал. Овог аймгийн нийтийн ашиг тусад зориулж “табу” бүтээгээд зайлшгүй мөрдлөг болгосон нь бүхэнд илэрхий. Чухам ийм үйлдлийн хүрээнд өөрсдийн гэх хамтын хоригийг бий болгожээ. Үүнийг З.Фройд хамтын мэдрэхүйн тэмүүллийн үр дүн гэж үздэг. Тодруулж тайлбарлавал, иймэрхүү үйлдэлт шинж хүмүүн төрөлтөнд төрөлхийн биш, байгалиас заяамал зүйл ч бас биш гэдгийг тэрбээр ахин дахин тодотгодог.

Бидний судалснаар, монголчуудын хувьд ертөнц гэх ойлголт нь ертөнц бустай зэрэгцэн нүүдэлж бүтдэг байх юм. Иймээс л юм [ДҮРС] бол үйлдэл [АМЬ] зэрэгтэй эн тэгш бэлгэ бэлгэдэлтэй зүйл байж, дүрсээр амийг нь зольж авдаг дом шившлэг нь биелэг-зан үйлийн хүрээнд уламжлагджээ. Энэхүү заншил [УТГА СОЁЛ], хэв ёсоо үр хүүхдээ мэдээ орох үеэс нь эхлүүлэн мэдрүүлж, хөдөлгөөн зангыг сэтгэлд нь хоногшуулж идээшүүлэхдээ сайн муугийн ёр бэлгийг урьдаас бодолцон үйлдэж, хөдлөх ёстойг сургамжилдаг билээ. Тэр ч бүү хэл, явах хөдлөхийн учрыг ердийн үйлдлээс эхэлдэгийг энгийн ухаанаар тайлж, тайлбарлаж байж. Тухайлбал, хаалга бүү сав,

гэрийн сүлд зайлна гэх юмуу, хөгшдийн урдуур бүү гар, буян барагдана гэх жишээтэй. Ингэж явах хөдлөхийг төдийгүй, ерөөс хөдөлгөөн бүрт ёр бэлгэ буйг сануулан сэрэмжлүүлдэг бөгөөд үйл хөдлөлийг зөв үйлдэхгүй бол дараагийн үйлдэл эс бүтэх тухайд сургадаг байсан аж.

Тэгэхдээ байгалийн эзэн биегүй юмс үзэгдлийг амьдчилж бүтээнэ гэдэг нь алга хавсран таших дуу чимээний хүч шиг хөдөлгөөн сүрийг тайх үйлдэл дохионы шид байж, урьдаас шарх оноон гэтэлгэхтэй адил жатгад хамаатай ойлголт байх нь. Цаашлаад, малыг гаршуулах явцад хонийг тойглох, ямааг гүүглэх, ингийг хөөслөх, гүүт гурайлах зэргээс гадна тагнай таших, уруул товших, исгэрэх мэтийн зан үйлийн аялгуулал болж хувирсан гэх баримт нэлээд байдаг. Үүнд тагнай таших нь гаслан зовлон учрахын, уруул товших нь хүйтэрхийн, исгэрээ нь сэрүү татахын тэмдэг зөн болж ойлгогдоно. Иймээс л үйл үйлдлийн мөрийг засах [ЦЭЭР ХОРИГ] гэх үүтгэлийг монголчууд [НААДААН]-аар сэлгэж ойлгож иржээ. Наадаан бүрт заншил, бас хөдөлгөөн ёс дагалддаг нь жам юм. Үүнд “сүнс”, “сүлд” хэмээх ойлголт ч хамтдаа яригдах учиртай. Давтан хэлэхэд, эртний хүмүүсийн үйлдэл болон бодол санаанд дараагийн болох үйлийн ёр бэлгийн угтал хамтдаа агуулагддаг. Энэ нь амь [НАСЫГ] сахиулсан эзэн [СҮЛД] буйг давхар хэлээд байгаа юм. Тэгэхлээр, овог аймаг бүхэнд заавал сүлдэн онго хэмээх сахиулсан эзэн байх ба ёсыг ёсоор эс үйлдвээс сүлд хаяхын дохио байдаг учиртай. Сүлд доройтвол сүйрэхийн тэмдэг. Иймээс наадаан гэдгийг сүнс сүлд бий гэх төсөөллөөс уламжилсан олон янзын зан үйлийн хэлбэр гэж ойлгож болох талтай. Үүний нэг хэлбэр нь бий биелэг хэмээн бид үзэж байна.

Баруун монголын олон ястанд түгээмэл буй [ЦАЦАЛ], [МӨРГӨЛ] биелэгт урьдах зан үйлийн улбаа мөр илүүтэй хадгалагдсан нь анзаарагддаг. Мөргөл бий гэхэд уул усны эзэн сахиус, элэнц хуланцын сүнсээ амар байлгах үйл мөрийн ая тэмдэг байж, цацал бийд гарын алга дандаа дээш харж байх нь хангай дэлхийдээ сүүн цацал өргөж, сайн сайхныг (хур бороо дуудах) урин дуудахын дохио болдог. Биелэгийг биеэр үйлдэх дохио зангын нэг улбаа гэж үзэхийн учир нь бие эрхтний хөдлөлд хожмоо ирэх үйлийг урьдчилан болгоон засах зөн давхар агуулагдаж байгааг хэлээд байгаа юм. Тэгэхлээр заншсан үйл хөдлөл гэдэг нь зөвхөн үзэгчдэд зориулсан уран хөдөлгөөний цогц чуулбар бус харин эртнээс нааш хүн, амьтан, байгаль дэлхийн далд хүчийг аргадах чадал үйл байсныг нотлох мэт.

Ялангуяа сүлд хийморийг даллаж дууддаг эртнээс тогтсон зан үйлийн улбаа буй бөгөөд хөдлөл суудлыг болон зам мөрийг засаж гэтэлгэвээс аливаа ад зэтгэрээс түр боловч ангижрахыг дохиох зөн хувьтай. Бөө мөргөлийн ёсоор бол хүний сүлд зайлвал бүсийг нь тайлан, хэт цахиурыг цахиж бөөлөөд сүлдийг эргүүлэх ёстой. Энэчлэн сүлдээ тайж тахиу уламжлалд онго тэргүүтнээ сүнс хэмээх ухагдахуунтай нэгтгэн холбож үздэг байна. Онго сүлдээ тайгчийг бөө буюу [БҮГҮ] хэмээнэ. Задалж тайлбарлавал, эртний түрэгийн [БҮГҮ] гэх үг “мэргэн төлөгч” гэсэн утга илэрхийлдэг бол, эртний түрэг хэлний [БҮ-ДИК]<sup>4</sup> гэх үг шид хөөх буюу хөдөлгөөний хүч чадлаар золигт гаргах ёслолыг заадаг. Харин бүдик гэх үгийн хувилбарыг Э.Севертяны этимологи толиноо<sup>5</sup>

<sup>4BŪDIK бүжиг /Махмуд Кашгарийн толь МК I 412/ хэрвээ хэн нэгэн зүүдэндээ хөөр баяр тоглоом бүжгийг үзвэл/Күтадгү Билик QBN 431/ гээд **buḍik** хэмээх хувилбар байдгийг дурджээ. /Древнетюркский словарь. Л.: «Наука», Ленинградское отделение. 1969. с.131/</sup>

<sup>5I БИЙ /BIJ кир., ккал.; **би/bi** кум., каз.;</sup>

нягтлан үзвэл хожмоо [БИЙ БИЕЛЭГ] хэмээн киргиз хэлнээ тогтож, улмаар манайхны хотон нарт уламжлагдсан байж болох юм. Тухайлбал, баруун монголд одоо хүртэл гараа хумьж, бүсэлхийг тойруулан мөрөө хаялж, гараа сацан биелэдэг нь үүний ул мөр бөгөөд гар хөлөө зөрүүлж хөдөлгөдөгт ч утга магад өгүүлэгдэнэ. Ийм цацал биелэг байгалиа төдийгүй овог бүлгийн сүр сүлдээ тайхаас эхтэйгээс гадна дөрвөн тал, найман зовхистоо мөргөж заншжээ.

Баруун, зүүн эргэлэгийг зөрүүлж үйлдэх бинар (давхар) утгын дор салангид эргэлэг хөдөлгөөн бус, хамт хавсарсан эргэлэг л хамтдаа ёсочлогддог. Гэхдээ биелэгийн үндсэн бүтцэд нэгжийн шатлал нь зүүнээс баруун руу, баруунаас зүүн рүү чиглэсэн байдаг нь [ХАМ] утгалбар хөдөлгөөн байдгийг анхаарах хэрэгтэй. Ялангуяа [УДГАН] гэх зүүн эргэлэг тун чухал. Юнгийн тайлбарласнаар бол ухамсарт үйлдэл нь бэлгэдэх үйлдэлтэйгээ хамт төсөөлөгдөх тэр хэв шинж нь [АРХЕТИП] мөн гэж үздэг. Тэгвэл, эргэнэ (зүүнээс баруун, баруунаас зүүн рүү сөргөж дохионо) гэдэг нь мифлиг нэгжүүдээ (мифологем) тайхын зэрэгт хариулгыг болгооно гэсэнтэй утга дүйнэ. Үүнээс эргэцүүлэхэд, монголчуудын уламжлалт биелэг бол дан ганц хэрэглээний шинж ахуйлаг сэтгэмжтэй бус, харин зөн увидас, бэлгэдэл гэх дотоод мэдрэмжийн түлхэц цочрол, түүний элементүүдийг хөдөлгөөнд төлөөлүүлж, цаашлаад зан заншилдаа

II **БИЙИ-/BĪJĪ-** кум., ног., KW<sub>57</sub>, Мел. АФ<sub>084</sub> (**бичи, бийичи** ‘бүжигч’ –ийн бүрэлдэхүүнд ‘), Ibnū B=M.<sub>21</sub>; **бийй-/bijjī-** тат., P IV<sub>1790</sub> (казан.), **бийй-/bĭjī-** баш.; **би-** P IV<sub>1737</sub> (куман.) **бүди-/būdi-** ДТС<sub>131</sub> (ТТ X<sub>145,469</sub>), Gab. II<sub>333</sub>, ТТ X<sub>43</sub>, Lig. VSOu<sub>147</sub>; **бүзи-/būdi-** ДТС<sub>131</sub> (МК III 259), Brock.<sub>46</sub>, Kašg. D.<sub>122</sub>; **būti-** ДТС<sub>134</sub>; **бүйи-/būji-** каз. диал. КТДС<sub>75</sub>; **beji-** KW<sub>54</sub>;

III \***би-** (**biğiṣ** ‘бүжигч’ –ийн бүрэлдэхүүнд) P IV<sub>1742</sub> (кир.=каз.), **би** Мел. АФ<sub>083</sub>; **bai-** Houts.<sub>60</sub>;

IV \***пийе** /**pīje** (**пийеле** – ‘бүжих’, ‘бүжиглэх’ –ийн бүрэлдэхүүнд) алт. ГАЯ<sub>237</sub>, P IV<sub>1329</sub> (алт., леб); **бид’е** /**bid’e** алт.; **бити** /**biti**: як.

МА<sub>123</sub> д **bijidi** тэр **бүжиглэв** гэсэн үйл үг гарах ба түүнчлэн (415 х) энэхүү дурсгалыг хэвлүүлэгч **bijidi** хэмээн засах хэрэгтэй гэж тэмдэглэж байна. Түүнчлэн татар аялгуунд байх **бийж** – монгол хэлнээс зээлсэн “бүжих” хэмээх зээллэг үгтэй харьцуулна уу. (ДСТ<sub>83</sub>).

I 1. **Бүжиг** – бүх дурсгал бичгүүдэд;

II 1. **Бүжиглэх, бүжих** – бүх дурсгал бичгүүдэд;

2. Гар ба хөлөөрөө хэмнэлтэй яруу хөдлөх ТТ X;

3. Гарлын хувьд шилжсэн утга “долигонох бөхөлзөх” – баш.;

III \* **бүжиглэх бүжих**;

IV 1. **Бүжиг** – алт., як., Буд.; **бүжиг** – алт., як., P I<sub>1329</sub> (алт., леб.);

2. нэг газар дэвхцэх, үсрэх – як.;

3. агаарт нисэн халих, дүүлэх, чичрэх /шувууны/ – як.

- Хуучны бичвэрүүд дэхь язгуурын эгшийг Ж. Клосон монгол хэлнээ тулгуурлаад **-ө-** хэмээн уншсан. (СI.<sub>300b</sub>, түүнчлэн СI.<sub>303b</sub>, 309b г харна уу). Гэвч сүүлийн бичвэрт **bezig**, мөн **byziğ** /**бүжиг** ‘бүжиг’, ‘театрын үзүүлбэр’, ‘тоглоом’ (Less.<sub>129, 153</sub>) гэж байгаа ба, М. Кашгарийн «Диван»-д бичигдсэн баримтыг **-ү-** болон **-ө-** тэйгээр мөн уншиж болно;

- **biji-, bij, būdi-** гэх мэт хэлбэр, утгын жагсаалтыг Ras. VEWT<sub>91a</sub> д үзнэ үү. Г. Рамстедт монг. **°bōzi-/būzi-** (**byzi-** /**бүжих** Less.<sub>153</sub> тай харьцуулна уу) ‘бүжиглэх’-ийг адил утгатай як. **bitii-**, кир. **bij-** тай харьцуулсан (Ram. KWb. 54). Тэрбээр Халм. **bī** ‘бүжиг/ийг’ кир. **bijū, bijiw** “бүжиг” ээс танец’ (стр. 47) ээс, **bilxe-** ‘бүжиглэх’ хэмээх үйл үгийг тюрк. **bij-, bijil-** гэх нэгэн адил утгатай үгээс гаралтай гэжээ. (мөн тэнд). Г. Рамстедт өөрийн сүүлийн үеийн солонгос хэлний гарлын судалгаандаа дээрх эгнээнд хятад солонгос хэлний **mū-** ‘бүжиг’-ийг монгол хэлний **būzi-** (<\***bū-di-**) ‘танцевать’ үгийн \***bū** язгуур гэж үзэж байв. (Ram. SKE<sub>152</sub>).

утгашуулж ойлгох дохио зангын синкретик тогтолцоо мөн гэх хэлж болохоор байна. Маш товчхондоо бий биелэг хэмээх энэхүү гайхамшигт зүйлээр хүмүүнд сэтгэл засал хийх боломжтой гэсэн үг. Хамгийн наад захын жишээ нь, Хүрээ хошууны болон Монголжины овог аймгийн дунд байдаг бага залуу эмсийн өвчнийг засах [АНДАЙ ДЭВСЭЛ] хэмээх зан үйл болно.

Дэвсэл бүжгийн талаархи мэдээллийг нягтлан үзвэл, “гадаад талын дүр дүрслэл” гэхээсээ илүүтэй [УД МОД] тайх, галын ёслол буюу уул усны эзнээ аргадан хөгжөөж, бүл олноороо үйлдэхийн учир холбогдолтой зан үйлийн улбаа болох нь тодорч харагдана. Ингэж дэвсэн бүжиж тайхын ул мөр Төв халхын бүжиг болон өнөөгийн буриад зоны ёохор, еэхэрт уламжлагдсан гэдэг нь ортой билээ.

Нөгөө талаар биелэгийн хөдөлгөөн ба амьсгал гэдгийг салгаж ойлгож болохгүй. Амьсгалыг хөдөлгөөн, эргэлэгт тохируулах нь анхаарал төвлөрөхийн үндсийг бүрдүүлдэг гэж биелээчид үздэг. Амьсгал авах, гаргах [ОРЦ ГАРЦ] эрчмийн урсгалаар ухамсаргүй үйлдлээ зөн үйлдэл болгож, цаашлаад байршил чигийг мэдрэх тутам биеэр хэмнэлийг илэрхийлэх боломж өгөгдөх нь тэр. Ийнхүү амьсгалаа тохируулан бясалгаж, хийг хөдөлгөөнд шилжүүлснээр үйлийн нууцад нэвтрэх түлхүүр [КОД] сэрж мэдрэгддэг билээ. Үүнийг хожмоо [ЛҮН] буюу [ХИЙ] гэж нэрлэх болсон хэдий ч [ГАЛБИРШИЛ] гэж ойлговол зохино. Хүний биеийг [БИЧИЛ САНСАР] гэж загварчлавал, биеийг нэвтрэн гүйх хий (лүн) нь нар, сарны эрчимтэй дүйнэ. Сарны эрчмийн хөдөлгөөн нь төвд тэмүүлэх хүчний эргэлэгтэй байхад, нарны эрчмийн хөдөлгөөн эсрэг чигтэй буюу төвөөс зугтах хүчийг эрхшээх нь бий. Амьсгалын урсгал хөдөлгөөнд орчихдоо зөвхөн баруун зүүнийг биш, бас доод дээд төвийн хүчийг нэгтгэх боломжтой. Энэчлэн ертөнцөд хөдөлж, үйлдэгдэж байгаа аливаа зүйл зүүн талынх нь сарны, баруун талынх нь нарны эргэлэгтэй урсгалаар үеэлзэж, үеүд нь гадагш, дотогш байх авч дор бүрнээ дан, давхар утгыг тээдэг. Юм бүхэн учиртай байхын нэгэн жишээн дор савыг тавихдаа сэнжийг гадагш, амсрыг дотогш өөд харуулах ёстой. Гадагш сэнжийг эс харуулбал гарз гарахын дохио байх болно. Хөдлөл, чиг бүрт учир утгагүй дохио занга үгүй тул хааш, аль зүг рүү хэрхэх нь үйлийн [ГАРЗ-ОЛЗ] мөрийг дохиох нь илт ажээ. Үүнээс гадна эмэгтэй хүн биелэхэд гэрийн зүүн хаяаг сөхдөг байхад, эр хүн биелэвэл эсрэг талыг нь сөхдөг байх жишээтэй.

Иймэрхүү дохио занга бүхий мифлиг бүтцийг дүрчлэн ойлгоход сакраль тэмдэг гол үүрэгтэй. Тэгэхлээр ёсочлогддог бүхэн зан үйлээр илэрхийлэгдэхдээ хориг цээр болж хувирдаг. Үүний жишээнд мал ахуйг өвчин дайрваас [ЦАГААН МОД] орхиулж шившин домнодог эртний монгол зан үйл багтана. “Цагаан модоор” (угтаа ичрэгээр ерөндөг тавих тайлга) ад зэтгэрийг дарах наадгайд хамтын ухамсрын харилцаагаар (сүсэг, үйл, тэмдэг) шийдэх ёр бэлгийн дохио давхар давхар илүү өргөн ёсочлогддог. Хар хүчийг ерөндөгийн чадлаар дарах (биеэр үйлдэх) дохиолбор хөдөлгөөн ч гэсэн ялгаагүй жир (сайн-муу) шинжтэй байхын дээр хүмүүний ухамсаргүйн сэрлийн түлхэцээ зөнгөөрөө үйлдэл болгон хэрэглэдэгийг судлууштай санагдана. Бидний тоглоом наадгай гэж нэрлэчихсэн дом шившлэг бүхий биеэлбэр тахилгад шидийн сэтгэмжээс илүүтэй ахуйлиг үйлдэл голлох үүрэгтэй болсон нь анзаарагддаг. Угтаа умай (удган) эхийн домоос үүдэлтэй бөгөөд амьдралаас үхэл рүү, үхлээс амьдрал руу чиглэсэн тодорхой бүтцийн хөдөлгөөнд орчино. Ийм “бинар” сэлгэлт нь яваандаа мал ахуйн үржих ба эс үржих, эсвээс сааль сүү тасалдах ба үл тасалдах тухай, [ГАРЗ ОЛЗЫН] төсөөлөл шиг ад зэтгэрийг аргадан давах үйл үйлдлийн явцаар илрэх болжээ.

Малд гай даарсныг даран гэтэлгэх арга жатгыг зан үйлээс нь нягтлахуйд зөнгөөрөө үйлдэж байгаа бүхий л үйл наадааныг хүмүүс дур мэдэн сонгож авдаггүй байжээ гэдэг нь мэдрэгдэнэ. Бүр цаашилбал, эцэг эх болох тэмүүлэл ч тэр, бэлгийн дур хүсэл ч тэр наадаан тоглоомд илрэн гардаг гэж хэлж болно. Үүний цаана нөгөө хамтын үл ухамсарлахуй гэгч бий. Тухайлбал, умай эхийн тайлга ёсонд хүн (ичрэг-эр үүтгэл) ба байгаль (газар-эм үүтгэл) хоёрын хамаарлыг онго ба шидээр зэрэг цагжуулах ба адилсган төлөөлүүлэхэд тэдгээрийг тайх ба хэрэглэх гэхчлэн (бибинар) дохиолбор зангыг үйлдэж байж. Тиймээс л харанхуй болмогц малын гай барцдыг дарахаар наадан домнож, шившин дархалдаг бөгөөд эр бэлгийн хүч чадлаар (ичрэг) ерөндөглөн өвчин хуйг үлдэн хөөхөөр багачуул залуусыг хайлгаж наадуулна. Цагаан модны барьбарыг (хэмжээг) ганц барим, дөрүүгээр ёсочлодог нь ч учиртай. Энэ юу гэсэн үг вэ? гэвэл ичрэгийн урт нь найман хуруу, бүдүүн нь барим байхыг дохиолсон хэрэг. Хайхын бэлгэдэлд ерөндөг цохих ба үйлдүүлэхийн хам [БИНАР] ёгтлол багтана. Нэг ёсондоо газар үтгээ (нуудгай) эр үүтгэлийн хүчээр дарна гэсэн утгатай дохио байна. Юутай ч “уургын чинээ озхай, уутын чигээ үтгэхэй”, эсвээс “үгийн ил нь сайн, үтгийн далд нь сайн” гэхэв дээ. Ингэж л монголчууд малын дархлааг наадаж, домнож чаддаг гайхалтай арга жатгатай байж. Ер нь юмыг бэлгэднэ гэдэгт нэг талаас адилтгахын (төлөөлүүлэх), нөгөө талаас хэрэглэхийн (үйлдүүлэх) хувь бий гэж К.Юнгийн хэлсэн утгыг давтахаас өөр хариулт эс олдлоо. Бас нэг содон тэмдэг бол цагаан мод хаяхад уургыг заавал газарт босгодог дохио байдаг. Уурга босгосон байвал ойртож үл болохыг хүн бүхэн мэднэ. Үүнээс үзвэл, домнон шивших наадгайд биеэр үйлдэгдэх [БИЙ] хамтаар оршдог төдийгүй зөн бэлгийн үйлдлээ ухамсарт үйлдэлд хувирган ойлгохын зэрэгцээ галбиршуулан хэрэглэж байсан нь тодорхой боллоо. Наадаж тоглохдоо ураг төрлийн хүйн холбоостой адилаар, тэгэхдээ [ДАЛД ЮМ-ЗӨН СОВИН]-ийн илрэлээ [ХҮН-ҮЙЛДЭЛ]-ийн харилцаагаар сэлгэж, түүнийгээ угсаа соёлын архетип болгосон нь бүр гайхалтай. Энэ бол зөвхөн нэг л баримт.

Монголчуудын дунд ихэд тархсан өөр нэг наадгай бол [ТАРВАГАЦАХ]. Тарвагацах нь газраар соёх үйлийн зан заншилд хамаарах агаад хэдийгээр чоно тарвага гэх боловч нөхөр дайсныг ялгахын, бас чоно тарвага хоёрыг нэгэн онгоцонд ундаалахын (эвсүүлэх) тухай миф гэж ойлгож болно. Чонын үнэр авч байж мал “мал” болдог гэх хуучуулын ярьдаг ч оргүй зүйл бишээ. Иймэрхүү [МИФЛИГ] сэтгэлгээг хүмүүс өөрсдийн зөн совингоо кодолож ойлгож байсны нэгэн жишээ гэж үзэж болох талтай. Тарвага бол үнэндээ тарвага биш, харин [ГАЗАР] хэмээх эм үүтгэлийн орон. Оронгийн бэлгэдэл нь өмөг буюу гэр (нүх) болой. Нөгөө талаар тарвага гэхийн цаад ёгтлолд өвс ургамлын шимийг танигч [УДГАН ЭХ] гэх тэмдэг оршино. “Тарвагатай газрын мал тарган” гэдэг үзэл эндээс эхтэй билээ. Багачуулаа “...чоно гуай, чоно гуай...галаа өгөөч” гэхчилэн наадуулж, чононд баригдахгүй байхыг сургадаг монгол ёсны угт байгалийн зохицлыг [МИФ-АРХЕТИП] болгосон ухаан тээгдэж байдаг. Домогт ертөнц зөвхөн нэг загвараар оршдог хэмээсэн Э.Кассирерийн санаа үүнд бий. Ингэж л монголчуудын дунд онго ба шидээ тайх ёсоо домгийн мэдрэмжээр хувилгаж, улмаар биеэр үйлдүүлэн амьдчилж наадах, домнож зайлуулахын бэлэг тэмдэгшжээ.

Наадгайн хөдөлгөөнт бүтэц нь тэмдгийн тогтолцоог загварчлан тодорхой бэлгэдлийг оноож байгааг анхаарах нь зүйтэй. Яагаад гэвэл, наадгай бол миф төдийгүй [БИНАР] үзэгдэл. Давхцал (зэрэгцмэл) утгалбар наадгайд заавал бий. Тухайлбал,

[ОРШИХ] нь дангаар биш, харин [ЭС ОРШИХ]–тойгоо хамтаар зэрэгцэн нэгэн дор заяагддаг. Хариулга хийх занга жатга мэтийн хүнээс гарч буй бодол санаа нь гагцхүү бие махбодын хэрэгцээ биш, харин тэдгээрийн цаадах гадаад ертөнцөд хандах хандлагын илрэл юм. Өөрөөр хэлбэл, хүн дарах, дарагдах хоёрын аль нэгийг сонгоно гэсэн үг. Иймээс л “биеэ мэдэхээр хүн, билчээрээ мэдэхээр мал” хэмээсэн биз. Хууцчуулын “чоно байгаа газрын мал эрүүл” гэхийн учир ч үүнтэй адил. Тэгэхлээр “чоно-тарвагацах” гэсэн нь “ургамал-амьтан” гэдгээр солигдоод зогсохгүй “амьдрал-үхэл” гэсэн дохио болж байна. Үүнээс эргэцүүлбэл, тэртээ үед монгол нутагт идээшин суугчид нь ан ав зонхилон эрхэлж байсан тул биеэр үйлдэх хөдөлгөөн занга мөн л амьдралаас урган гарчээ. Ялангуяа ан амьтныг хөөх, бүслэж агнахаас урьтаад гороо үйлдэх тайлгаас тойрон хатирах дом үүссэн гэдэг. Энэ үйлийн улбаа хожмоо мал ахуйгаа мэнд амар байлгах заншилтай холбогдсон ба сааль сүү элбэг, сүрэг тарган, өвчин зовлонгүй байх хам дохиолбор занга байдаг. Тодруулж хэлбэл, маш эртэд ан ав, мал ахуйн холбогдолтой биеэр үйлдэх наадгай үүсэж буй болсноор [ЗАН ҮЙЛИЙН БҮЖИГ] гарсан гэж үзэх үндэстэй. Ийнхүү дом (зурлага), шившлэг (чимээ), биеэлбэр (бий) бүгд л мифлиг үүдэлтэй, синкретизмын шинжтэй алогик сэтгэмжээр үүсэж бий болжээ. Биеэр тайх ёслолтой холбоотой баримт неолитийн үеэс эхтэй бөгөөд тэр нь голдуу хадны дүрс байна<sup>6</sup> хэмээн зарим судлаачид тэмдэглэжээ.

Онцолвол, хүй нэгдлийн үеийн дом шившлэгийн шид (мистик) бүхий сүсэг-зан үйлийн хориг цээр нь аливаа ертөнцийн хүчийг зөвхөн эр, эм үүтгэлээр төлөөлдөг биш, гомеопатик төсөө төсөөгөөр илүү чадалтай болгоодогт байдаг. Үүнтэй холбогдох тайлбар монголын хадны зурлагын дурсгал дотор нэлээдгүй байна. Жишээ нь, нар сар, бүргэд шонхорыг дээдлэн эрхэмлэдэг ёс үйлдэлд дал хүчний амирлал зайлшгүй эрхшээгддэг. Түүгээр ч үл барам эрхсийн тэмдэг нь уул усны эздийг аргадах үйл зорилгоос шалтгаалан дотроо олон янз болж тэмдэгшжээ. Дорно дахинд үхэр сарын адаг, бар сарын эхэнд ад зэтгэрийг зайлуулахдаа заавал нэг амьтныг золигт гаргадаг ёс буй. Бидний судалснаар, Их Тэнгэрийн аман дахь сүг зурлагын учрыг тайлаагүй байхад Оросын эрдэмтэн А.П.Окладников Гацууртыг иймэрхүү төрлийн зурлага дэлгэрсэн хамгийн урд хязгаар, Байгаль нуурын хавь газар нь хойд хязгаар болох тухай бичсэн байдаг.<sup>7</sup> Үнэндээ тэдгээрт зурагдсан шувуун дүрс нь бөө мөргөлийн түлхүүрээр бол нар хэмээх утга болой. Зөвхөн Гацууртаар тогтохгүй монголын баруун хэсэг тухайлбал, Хөвсгөл аймгийн нутгаас тиймэрхүү зурлага бүхий тэмдэглэгээ олдож буй нь ийм тайлга тахилга нэлээд өргөн дэлгэр тархсаныг магадлана. Эдгээр сүгийн зүйлийн баруун хил нь Хөвсгөл аймгийн Хөгийн гол, зүүн тал нь Гацуурт, урд тал нь Их Тэнгэрийн ам, хойд зах нь Улаан-Үд хотын хавь, Сэлэнгэ мөрний сав газар хүртэл үргэлжилж байгаа нь ихэд сонирхол татдаг. Ийм дүрс зурлагын утгалбар дан хадны сүгт бус МЭӨ 1200-700 жилд хамаарах Карасурын соёлын үед холбогддог хүрэл хутганы ишинд дүрслэгдсэн байдгийг судлаач эрдэмтэн С.В.Киселев, В.В.Волков нар дурдаад, тэр нь ан авын олзыг урьдаас хэтийдэж оноох, эсвэл элдэв төрлийн шидэд итгэдэг байсны гэрч хэмээн өгүүлсэн нь тохиолдлын зүйл биш бололтой. Түүнчлэн шувуу, хүний дүрсээр өөрсдийн онго сүлдийг сэтэрлэж хамгаалсан, өөрөөр хэлбэл

<sup>6)</sup> Сономцэрэн Л. Монголын эртний соёл урлаг, УБ., тал 72.

<sup>7)</sup> Окладников А.П. О датировке Забайгальских писаниц-Записки БМНИИК, вып XVI, с.58



сахиулсан зүйлсээ тахин шүтдэг шувуунд (бүргэд) давхар даатгасан<sup>8</sup> гэх тайлбар бий. Бидний мөшгөсөн баримтаар, солонгосын бөө мөргөлийн “Сандэ Кү” гэдэг багт бүжгийн төрөл болох “Талчүм” хэмээхэд бас л ийм дохио зангыг үйлдэн тойрон бүждэг. Энэхүү Талчүм жилийн тогтмол өдөрт овог аймгийн хийморь сүлд, ус билчээрийн шим, муу муухайг зайлуулах үйлийн ёгтлол болж хэрэглэгддэг. Хамгийн сонирхууштай нь хөлөөр дэвсэн харайлж байгаа хөдөлгөөн болно. Гараа дээш алдлан, хөлөөрөө газар дэвслэн тойрч шавахтай төсөөтэй хөдөлгөөн Их Тэнгэрийн ам болон бусад газрын хадны зурлагад нэгэн адил байгааг анхаарууштай. Хүрэл зэвсгийн дунд үед ийм шүтлэгийн хэлбэр тус газарт байсан бөгөөд хоёрдугаар сарын гуравдагч өдөр энэ ёс үйлийг гүйцэтгэдэг байж. Тэрхүү ёслол нь хуучны тооллоор өвлийн сүүл сарын 29-ний өдөрт үйлддэгдэг байсан бололтой. Үхэр сарын сүүлчийг сайн давсныг бэлгэдэхийн учир нь жилийн өнгөнд ад зэтгэрийг даран арилгаж, угтах улирлын сайн сайхныг урин дуудахаас үүдэлтэй дохио байж, тэгэхдээ үхрийг домносон сүг зурлагыг заавал дагуулан өргөдөг. Энэ нь ч хадны зурлагын дом шившлэгтэй тохирч байгаа юм (Зур.1). Үүнээс үзвэл, бөө мөргөлд төдийгүй түүнээс өмнөх тайлга тахилгын дом шившлэгт гараа өргөн уухайлах, газар дэвсэн цамнах явдал байсныг гэрчилээд зогсохгүй МЭӨ 1200-700 жилийн тэртээ занга жатга тавих зан үйлийн биелэг хэдийнээ тогтсоныг хэлэх мэт. Уламжлаад, хожмоо ураг тариг барилдах зан үйлийн бүжигт өвлөгдсөнийг “Басганы их наадаан” бэлхнээ харуулна. Буриадын заншилд буй “Басганы их наадаан” нь гэрлэх зан үйл хийгээд дуут бүжиг наадааны цогц болохынхоо хувьд “...орон дэлхийн эзэд, овоо уулын савдаг, ус лусын эзэд, онгод тэнгэр нар хотлоор баясаж, хоймрын хор, хотны тотгорыг тонилгож, залуусын хийморь цог золбоог бадраадаг”<sup>9</sup> тул ийн үйлддэг аж. Ингэж дуулж бүжихийг хамтатган “той” хэмээх нь ч бас бий.

Хаданд “хий сүг” босгох нэг хэрэг, харин түүнийг шившиж биеэр занга тавьж ёслох нь өөр зүйл гэж ойлгож огт болохгүй. Яагаад гэвэл, шившлэг үгүйгээр, үйлдэл хөдлөл үгүйгээр сүг [СҮГ БИШ] болно. Сүгээ амьшуулахад шившлэг, жатга, үйлдэл, занга оролцохгүй бол хоосон тэмдэг хэвээр үлдэнэ. Тахилч жатгачдын энд тэндгүй домнодог байсан шид үзүүлэх зан үйл дотор хар элгэтнийг төлөөлүүлэн сүг үйлдээд цээжийг нь нэвт сүлбэх юмуу, шатаах явдал бий. Ийм үйлдлээр хар элгэтнийг хороож, [ХОР ХӨНӨӨЛ] учруулж болно гэж үздэг байжээ. Хожмоо сор залах, солигт гаргах гээд бас л шатаадаг байсан. Манайхны заншлаас тэрхүү шатаан зольдог ёсны ул мөр огт салалгүй бараг өдгөөтэй золгосон байх юм.

Мистик сэтгэлгээний нууцлиг орчин руу орох тусам [ШИД ХӨӨХ] юутай холбоотой, яагаад синкретикээр үйлдэгдэх ёстойг бага сага гадарлахад хүрдэг. Тухайлбал, ан авын олз омог нь болох ёстой байдалтайгаа заавал дүйх шаардлагатайгаас л оноох амьтдаа сүлбэж, урьдаас авахаар аргадан тохирвол (дүрслэвэл) цаад зүйлээ эрхэндээ орууллаа хэмээн гөрөөчид итгэдэг байж. Одоо ч гэсэн дом [ДҮРС] үйлдэн золих зорилгоор хад цохион дээр элдэв сүг сийлдэг явдал хаа нэгтээ байсаар буйг Спенсер, Фрейзер болон бусад судлаачид баримтжуулсаар байна.

Дээрхи нөхцөл байдал урлагаас, тэр тусмаа бүжгээс хол хөндий мэт боловч чухамдаа хөдөлгөөнийг занга жатгаар оноож байсныг тодорхойлж өглөө. Гэхдээ үндсэн

<sup>8</sup>) Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг-Эртний судлал, угсаатны зүйн бүтээл, УБ., 1963, тал 9.

<sup>9</sup>) Гантогтох Г. Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал, УБ., 2007, тал 69.

шалгуурт бидний ярьдаг шиг гоо сайхны үнэлэмж биш, шидийн нөлөөлөл, [ҮЙЛЧЛЭХ] хүч чадал гол үүрэгтэй байсныг тэмдэглэвэл зохино. Үүний зэрэгцээ хөдлөл байршлыг дур зоргоороо өөрчлөх, эсвээс санаснаараа хөдөлгөөн зохиож болдоггүй байна. Харин үйл үйлдлийн ёр бэлгийн чадал хүчийг мэддэг жатгачдын хувьд [БИЙ] үйлдэнэ гэдэг чухлаас чухал ёс болой. Иймэрхүү зан үйлийн ил бус утга учрыг Жорж Фрейзер маш гярхай ажиглаж, түүнийгээ ургамлын сүнсний тухай төсөөлөл эс анзаарагдам байдлаар улирлын төлөөлөл [ДАЛД УТГА] руу шилжиж, тэр төсөөлөлд мөнөөх сүнсний чадал юутай хүчтэй илэрдгийг<sup>10</sup> магадтай тайлбарлаад, ургамлын сүнснийг зөвхөн ургамал бус, ургамал-хүн нэгэн зэрэг төлөөлдөг [ЗОМОРОФ-АНТРОПОМОРОФ] жишээг<sup>11</sup> дурджээ.

Иймэрхүү дом зангыг нүүдэлчин ардын ёс заншлаас үлэмж хэмжээгээр харж ажиглаж болно. Зад тавих (хур урин дуудах), зад барих (хур тогтоох, аянга цахилгааныг зайлуулах) шившлэгт задын чулууг ашиглахаас гадна алтан гагнуур, вансэмбэрүү зэрэг өвс ургамал, хус, заг модыг увидастай хэмээн үздэг тал байдаг.

Энэ нь угтаа, онголсон амьтан, ургамлаа цээр хориг болгож байгаа хэрэг л дээ. Онго шүтээн өөрөө шид босгох орчинг бүрдүүлэх мөртөө ялгамжтай бус, эсрэгцэлд захирагддаггүйг ямагт тунхагладагийг олон түүхчид<sup>12</sup> тэмдэглэдэг. Иймийн учир үзэгдлийн шинжийг гээдэг төдийгүй зохиомол зүйл шиг ч биш, гагцхүү сакраль хэлмэрээр шүтлэгийн ёсонд тэмдэгшдэг тухай Илиаде Мирче дахин дахин онцолдог. Яг тийм мөрдлөгөө мөргөл ёслолд бий. [РИТУАЛЬ] хоригт баригдмал байдаг бол, [МИФ] нь хувилбарших боломжоороо илүү нээлттэй байдгаараа өвөрмөц. Энэ нь тэдгээрийн голлох ялгаа. Тотемоо зурлага болгон тайх явдал монголчуудын дунд эрт дэлгэрснээр сайн муу бүхий л үйл үйлдлээ түүнтэй холбон үздэг байж. Үүний тухайд, шашны философич П.Флоренский “..сүг бол ёс үйлийн тэмдэг биш, уул усны болон бусад эзэдтэй харилцах нөгөө ертөнцөөр дамжих тэр үүд” хэмээснийг этно үйл үйлдлийн бинарчлалаар дүйлгэн ойлгох хэрэгтэй. Учир юун гэвэл, биеэр тайх янз бүрийн үйл хөдлөл нь бүжиг үүсэхээс өмнөх сэтгэмжтэй дам уялддаг ч гэлээ зан үйлийн язгуураараа шууд холбогдох нь ойлгомжтой. Амьдралын ашиг тус, аж төрөх, улмаар энх тунх тогтох мэтийн байгаль, нийгмийн онцгой үзэгдэл явдлын хор хөнөөлийг лус савдаг шиг шидэт хүчний гарц олзтой холбон, цаг цагийн шаардлагаар (ган гачиг нүүрлэх, өвчин тохиолдох) биеэр ёслолыг үйлддэг байжээ. Эхэн үедээ бүжиг гэх төрөлсөл байгаагүй боловч догшидыг аргадаг шиг газар дэвслэн тайдаг жатга занга байж л байлаа.

Тэртээ үед биеэр дом шившлэг үйлдэх, муу зүгийн юмыг дардаг “амбивалент” шинжтэй ёслолд [БАГ] өмсөж, тойрон нааддаг байсан нь лус савдгийг аргадах ёс болж заншигдсанаар залбирах үйл үйлдэл ч хамтдаа үүджээ.

Хий сүг босгон сүүдэрлэдэг ёслохуйн нэгэн адил хүний биеийн хөдөлгөөн-зангаар аливаа хорлолыг зайлуулан, эерэг бүхнийг урин дуудаж, тайж байсан нь өдгөө нэгэнт тодорхой болжээ. Тэгэхдээ гарын хөдөлгөөнөө болзолт дохиогоор шидчилэн үйлдэж, харин хөлийн дэвсэлт, эргэлтээр ад зэтгэрийг номхотгон, уул усны эздийг баясгахын шидийг тээдэг болох нь хожмын тодорхой баримтуудаар илэрхий боллоо.

Шашны нууц тарнийн ёсонд дохио занга, хөдөлгөөн бүрийн ёр бэлгийн хэлмэр оночлон заагддаг. Үүний жишээнд [ЛҮБА] хэмээх гарын цацлагат хөдөлгөөнөөр

<sup>10</sup> Фрейзер Ж.Ж. Алтан гишүү, УБ., 2011, тал 142.

<sup>11</sup> Мөн тэнд.

<sup>12</sup> Hauser A. The Social History of Art. L., 1957, p.27.

үйлийг намнах, зүүн хөлөөрөө эр шулмасыг, баруун хөлөөрөө эм шулмасыг талхлан дарах мөртөө [АВАД] хийгээд [ЁМЧИН] гэх их дэгэргэнээр дайсан тотгорын орон аймгийг машид үймүүлэн дэвсэх зэрэг хөдөлгөөнөөр үйлдэх ад зэтгэрийн хариулгыг авч үзэж болно. Иймийн учир хөдөлгөөний дэвслэг эрчим өөр хоорондоо ялгаатайг нэрлэвэл зохилтой. Тэгэхлээр, дайсан тотгорын орныг үлэмж ихээр үймүүлэн дэвсэхийг “Авад” хийгээд “Ёмчин” гэдэг бол, харин өчүүхэн төдий дэвсэн үйлдэхийг “Авад” хийгээд “Ёмчүн” гэх<sup>13</sup> нь буй. Ингэж л биеэр дом шившлэгийг үйлдэн байгаль, нийгэм, ахуй амьдралын элдэв саадыг давах, ад зэтгэр, хорлолыг зайлуулах зан үйл нь [ИТГЭЛ БИШРЭЛ], наминчлах үзэлд давхар уламжлагджээ. Нэрт төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатарын цамын судар шастирыг судалсан ажлын үр дүнд тухайн сэдэвт хамаарах мэдээ баримтууд тодорхой болсныг тэмдэглэвэл зохино.

Ийнхүү цамын дэг ёсонд хөдөлгөөн-үйлдлээр засахын зэрэгт “...нууц тарнийн зан үйлийн явдал лугаа тохируулан хэнгэрэг дэлдэх, цан цохих, дэлдэх, унших, урих, үг дуу эгшгийн зүйлийг харшуулахгүй цамнах”<sup>14</sup> -ыг номлосныг анхаарууштай санагдана. Үндсэндээ эндээс хөдөлгөөн-үйлдэл дангаар шившигддэггүй, харин дуу чимээний хүч, мөргөл залбирал, уншлагын хүчээр бүтдэгийг мэдэж болохоор байна.

Нөгөө талаар, цамын ёсонд хөдөлгөөн дэгийг нэгэн загварт хашиж болохгүйг чухалчилдаг. [ӨР] буюу эрчмийн голомтоо ихэд шүтэх болсон хийгээд уул усны эзэд савдаг тус тусын авир төрхтэй учраас, залагдах сүм хийдийн шүтээн анги ялгамжтай байхын үндэст цамын горим нутаг оронд бүрд ялгарах онцлогтой байдаг ажээ. Үүний нэгэн баримт нь, хангайн нурууны салаа салбарт орших сарлаг хайнаг ихтэй нутгаар тохиолддог, үхрийн мялан өвчнийг дарах үүднээс [БУХАН ЦАМ] дэглэх ёсыг Жалханз хутагтын, Шива ширээтийн хийдэд мөрдөж байсан гэж хуучилдаг. Мөн байгалийн гамшиг, элдэв үзэгдлийн цаад ёр хийг гаргах зайлуулах үүднээс цам харайлгах явдал байсныг зориуд тэмдэглэе. Хэдийгээр цамд бөө мөргөл, уул усны эзэн савдагтай холбогдсон [ЦАГААН ӨВГӨН] байх боловч дор бүрнээ өөр өөрийн бэлгэдэл, гэтэлгэх ёс ахуйг харгалзаж байж.

Заримыг дурдвал, савдаг Гомбогарав хэмээх Дэжээлэнгийн хүрээний Цагаан өвгөн нь төрийн хар хувцастай, нум сум үүрч, буга согоог хөөж харвах, хэт цахих, тамхи татах зэргийг үйлддэг байснаа 1905 онд тэр нутагт болсон их газар хагаралтаас хойш газар ус, гал салхины хорлолыг дарах [САЧУ-МЭЛҮНГЭ], [НОДБА] гэх шинэ дэг хэрэглэх болжээ. Ийм дэгд “... [ЧУ-РОДАВ] гэх усны ар, урсгал долгионы өрүү сөргүүг үзүүлсэн зөөлөн намуун хөдөлгөөн, [САР-РОДАВ] гэх газрыг илж тэгшлэхийн аяар амирлуулах хөдөлгөөн, [МЭ-РОДАВ] гэх гал түймрийг ширвэн цохиж, усны урсгалыг эргүүлэн авчирч буй эрчимт дорвилог хөдөлгөөн, [ЛҮН-РОДАВ] гэх ургамал модыг найгуулж ганхуулсан хий салхины уян налархай хөдөлгөөн, [ЖАГАГ-РОДАВ] гэж араатан жигүүртнээс хол ойрд хэл сураг дуулгах урт сүүлт цагаан хуй шаазгайн дөрвөн тийш дөрвөнтөө үсэрч дэвхрэх хөдөлгөөн, Цагаан өвгөний сав шим ертөнцийн амгалан тайван байдлыг саравчлан харж, [ЭРГЭН ХАЛИАХ ХӨДӨЛГӨӨН], эцэст нь [СӨГДӨН МӨРГӨХИЙН ХӨДӨЛГӨӨН], бас завсарт нь [АМЬСГАЛЫН ЦАМ] гэх амарч зогсохын хөдөлгөөн оролцуулан

<sup>13</sup>) Хүрэлбаатар Л. Судар билгийн шастир, УБ., 2002, тал 303.

<sup>14</sup>) Мөн тэнд.

нийт найман зүйлийн уран хөдөлгөөнийг үзүүлдэг болжээ.”<sup>15</sup> гэсэн нь үнэхээр гайхам үзэгдэл болой.

Эргэцүүлбээс, цам болон ардын бүжиг наадаанд ч ялгаагүй хөдөлгөөн галбирт домын хүч, эрчмийн чадлыг эрхшээдэг нь илт байна. Ингэж гүрэм дором үйлдэн дуу чимээний хүч, үйл хөдөлгөөний эрчмээр дом шившлэгээ тээх нэгэн жишээнд Ноён хутагт Равжаа бээр лагшин чилээрхэхэд заслын арга болгон зохиосон “Дагинасыг гансруулах буцаалтын горим” хэмээх гүрэм зайлшгүй орно. Энэ гүрмийг 1983 онд Дорноговь аймгийн Эрдэнэ сумын харьяат 76 настай Дамбын Довдонбалжир гуайн хуучилснаас улбаалаад эрдэмтэн Л.Хүрэлбаатар эх судрыг сурвалжилж олоод, тайлсан байдаг. Бүжгийн горимд аль үйл хөдөлгөөнийг хийхэд цан бишгүүрийг хаана, хэдийд, хэд хичнээн дуугаргах хийгээд хөдөлгөөн сэлтийг хэрхэн яаж үйлдэх, завсар зуур нь ямар тарни гүрмийг хэрхэн аялгуулан дуудах зэргийг нарийн тодорхой заасан байдгийг<sup>16</sup> судлаач тэмдэглэжээ. Ямартай ч, ад зэтгэрийг хөөх, солиг гаргах мэт үйлд тодорхой хэмнэл, зогсолт, үелзэлт хөдөлгөөн галбиршсан нь занга утгаших, мөр шалтгаанд захируулах ёс давтагдмал байсныг илтгэнэ. Лавтай нягталбал, хүмүүнийг хүрээлэн буй янагуух юмс буюу ертөнцийн үзэгдэх тал хийгээд түүний язгуурыг таних барих, тэгснээр хүмүүнийг ертөнцийн хүлээсээс гэтэлгэх лагшин, мутараар үйлдэлшүүлэн дохиолох арга чаргад цам- нууц тарнийн ёсны агуулга зохирчээ гэж үзэж болохоор байна. Нууц тарнийн дэг жаягийн суурь нь үзэл баримтлалын цогцыг, мөр нь төгс амирлангуйд хүрэх арга замыг, үр нь мөрөөр үйлдээн юунд хүрэхийг тус тус заах ажгуу.

Эцэст тэмдэглэхэд, домог зүйн сэтгэмж бүхий этнобүжгийн дохио хэлмэрт орон ба оронт, юм ба санаа хоёрын харьцаа эс ялгагдан, урьдын урьдаас ёр бэлгийн үүдэл сэрэгдэх аморф шинж уламжлагдсан гэж үзэхэд хүргэснийг хэлэх юун.

## НОМЗҮЙ

1. Ю.Болдбаатар (2008), *Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг*, Улаанбаатар.
2. Г.Гантогтох (2007), *Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал*, Улаанбаатар.
3. Ч.Далай (2009), *Монголын бөө мөргөлийн товч түүх*-ШУАТХ, Улаанбаатар.
4. Д.Дорж (1963), *Монголын хүрлийн үеийн хадны зураг*-Эртний судлал, угсаатны зүйн бүтээл, Улаанбаатар.
5. Л.Сономцэрэн (), *Монголын эртний соёл урлаг*, Улаанбаатар.
6. Л.Хүрэлбаатар (2002), *Судар билгийн шастир*, Улаанбаатар.
7. Л.Хүрэлбаатар (1992), *Монгол цам -Олон улсын монголч эрдэмтдийн ҮИ их хуралд тавьсан илтгэл*. (хэвлэлд) Улаанбаатар.

---

<sup>15</sup> Хүрэлбаатар Л. *Монгол цам -Олон улсын монголч эрдэмтдийн ҮИ их хуралд тавьсан илтгэл (хэвлэлд)* УБ., 1992, тал 9.


<sup>16</sup> Хүрэлбаатар Л. *Судар билгийн шастир*, УБ., 2002, тал 303.

8. Фрейзер Ж. Ж (2011), *Алтан гишүү*, Улаанбаатар.
9. Д.ЦЭВЭЭНДОРЖ (1999), *Монголын эртний урлагийн түүх*, ШУАТХ, Улаанбаатар.
10. Древнетюркский словарь (1969), Л., «Наука», Ленинградское отделение.
11. Окладников А.П., О датировке Забайгальских писаниц-Записки БМНИИК, вып XVI.
12. Севертян Э.В (1978). *Этимологический словарь тюркских языков*. Москва.
13. Gombrich E.H (1996), *The story of Art-Strange Beginnings*, W.
14. Hauser A (1957), *The Social History of Art*. L.

## SUMMARY

In a study of gestures and moves of ethnodance, it was found that not only its origin and amorphousness are derived from rituals of ancient religion and magical cure, but also certain moves have still been retained in folk games and several dance types.

The examples include games involving bodily movements and gestures such as, “Tsagaan mod orkhih” /Literally translated as ‘Throwing white stick,’ a game in which a stick is thrown out somewhere and people have to find it /, “Tarwagatsah” /Literally translated as ‘Playing as marmots,’ a game in which one plays as a wolf and others as marmots/ etc and such ritual dances as “Ud mod taikh” / Shamanic ritual where one set a willow tree and tie it with Tsalam strings and ask for goodluck/ and “Andai devsel” /a dance in which dancers hold colored strips of cloth in their both hands and when one singer sings others sing along while dancing/. As a religious ritual, their intensive repetitions of moves are believed to be merged with mantra rituals, represent methods of getting rid of any kind of limitations by its gestures and identify the nature as well as external qualities of the world we live in, in effect forming a comprehensive remedy of taming any evil spirit or malignity.



Зураг 1- Их тэнгэрийн амны хадны сүг зурлага. Неолит.

МЭӨ XV-XII зуун